

2023 он 12 сар 13 өдөр

Дугаар 24/28

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь хэсэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 12 сарын 13-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн “Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах, гүйцэтгэлийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд тайлagnаж ажиллахыг Гүйцэтгэх Захирал (Г.Цогбадрах)-д, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитор (П.Бямбасүрэн)-т тус тус даалгасугай.

ДАРГА

О.ОДБАЯР



12 сарын 19

АРД ДААТГАЛ ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны
өдрийн тоот тогтоолын хавсралт



АРД ДААТГАЛ ХК-ИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИДТАЙ ХАРИЛЦАХ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр (цаашид “Хөтөлбөр” гэх)-ийн зорилго нь компанийн хувьцаа эзэмшигч, ирээдүйн хөрөнгө оруулагч, санхүүгийн зах зээлд оролцогчдод компанийн үйл ажиллагаанд нөлөөлж болохуйц үйл явдал, засаглал, стратегийн зорилтын хэрэгжилт, хэтийн төлөв, санхүүгийн гүйцэтгэлийн талаар үнэн зөв мэдээ мэдээллийг тогтмол хүргэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дор дурдсан үр дүнд хүрэхийг зорино.

1.2.1. компанийн санхүүгийн болон санхүүгийн бус тайлагналын ил тод, нээлттэй байдлыг олон улсын сайн жишигт хүргэж, хөрөнгө оруулагчдыг үнэн зөв мэдээллээр цаг хугацаанд нь хангах;

1.2.2. хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, харилцан итгэлцлийг нэмэгдүүлэх;

1.2.3. компанийн зах зээлийн үнэлгээ бодитоор тогтох буюу компанийн хувьцааны ханшийг бодитой үнэлэх боломжоор хөрөнгө оруулагчдыг хангах;

1.2.4. компанийн засаглалын олон улсын зарчимд нийцсэн хөрөнгө оруулагчтай харилцах мэдээллийн сувгийг бий болгосноор ирээдүйн хөрөнгө оруулагчдыг татах, бизнесийн үнэ цэнэ болон компанийн засаглалыг сайжруулах.

1.3. Энэхүү хөтөлбөрийг Монгол Улсын хууль тогтоомж, компанийн дүрэм, журам, зааварт нийцүүлэн боловсруулав.

Хоёр. Хөрөнгө оруулагчидтай харилцах, мэдээлэл солилцох

2.1. Компани нь хөрөнгө оруулагчдад Компанийн Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд ил тод хүргэх дотоод журамд заасан мэдээллээс гадна дор дурдсан мэдээллийг компанийн цахим хуудас, Монголын хөрөнгийн биржийн сайтаар дамжуулан тухайн хөрөнгө оруулагчид саадгүй хүргэнэ.

2.1.1. жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан;

2.1.2. хувьцаа эзэмшигчдийн хурлын зар, мэдэгдэл, хурлын материал;

2.1.3. хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргалтад нөлөө үзүүлэхүйц бизнесийн болон санхүүгийн үйл ажиллагаанд бий болсон нөхцөл байдалтай холбоотой тухай бүр хүргэх мэдээлэл;

2.1.4. зах зээлийн судалгаа, шинжээчийн дүгнэлт;

2.1.5. хөрөнгө оруулагчдын санал, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэсэн байдал;

2.1.6. компанийн шаардлагатай бусад мэдээлэл.

2.2. Хөтөлбөрийн 2.1-д заасан мэдээллийг хүргэхдээ хүний эрхийн мэдрэмжтэй, тэгш хүртээмжтэй зарчмыг баримтална.

2.2. Компани нь дор дурдсан хэлбэрээр хөрөнгө оруулагчидтай харилцана.

2.2.1. хувьцаа эзэмшигчдийн хурлын үеэр компанийн санхүүгийн гүйцэтгэл, ТУЗ, гүйцэтгэх удирдлага, хөндлөнгийн аудиторын тайлан болон хурлын шийдвэрийн төслийг хэлэлцэж, санал авах, асуулга зохион байгуулах;

2.2.2. хувьцаа эзэмшигчдийн хурлаас бусад үед хөрөнгө оруулагчаас ирсэн санал хүсэлтийг цахимаар, амаар болон биечлэн хүлээн авч хариуг хүргүүлнэ.

2.2.3. хөрөнгө оруулагчид хариу хүргэхдээ Компанийн Нууц хамгаалах журмыг баримтална.



Ард даатгал ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны
11 сарын 13 өдрийн тоот тогтоолын хавсралт

Гурав. Хөрөнгө оруулагчаас санал хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх

- 3.1. Хөрөнгө оруулагч нь өөрийн санал хүсэлтээ дараах байдлаар компанийд ирүүлнэ. Үүнд:
 - 3.1.1. компанийн лавлах утас 77200088 дугаарт холбогдон аман хэлбэрээр;
 - 3.1.2. компанийн info@arddaatgal.mn цахим хаягт цахимаар;
 - 3.1.3. компанийд өөрийн биеэр ирэн цаасаар санал хүсэлтээ өгнэ.
- 3.2. Хөрөнгө оруулагчийн ирүүлсэн санал хүсэлт, гомдлыг хүлээн авсан ажилтан тэр даруй Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /цаашид “ТУЗНБД” гэх/-д хүлээлгэн өгнэ.
- 3.3. ТУЗНБД нь хөрөнгө оруулагчаас ирсэн санал хүсэлт, гомдлыг бүртгэн холбогдох газар, албуудтай хамтран шийдвэрлэх хүртэлх үйл ажиллагааг зохион байгуулна.
- 3.4. ТУЗНБД нь санал хүсэлт, гомдлыг шийдвэрлэхдээ мэргэжлийн ёс зүйтэй байж холбогдох хууль тогтоомж, компанийн дүрэм журмыг баримтлан цаг хугацаанд нь хурдан шуурхай шийдвэрлэж ажиллана.
- 3.5. Хөрөнгө оруулагчийн гаргасан санал хүсэлт, гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор хариуг цаасаар болон утсаар хүргүүлнэ. Шаардлагатай тохиолдолд Компанийн Гүйцэтгэх захирлын шийдвэрээр тус хугацааг ажлын 10 хүртэлх хоногоор сунгаж болно.

Дөрөв. Хариуцлага

- 4.1. ТУЗНБД нь хөрөнгө оруулагчаас ирүүлсэн санал хүсэлт, гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх тайлан мэдээллийг компанийн ТУЗ-д тайлагнана.
- 4.2. Хөтөлбөрийг зөрчсөн ажилтны үйлдэл, эс үйлдэхүй нь Компанийн нэр хүндэд хохирол учруулсан бол хөтөлбөрийг зөрчсөн этгээдэд Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хариуцлагыг буруутай этгээд хариуцна.
- 4.3. Компани болон Хөрөнгө оруулагчийн хооронд маргаан үүссэн тохиолдолд эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

Тав. Хяналт

- 3.1. Компанийн гүйцэтгэх удирдлага нь хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулна.
- 3.2. Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөрийн хэрэгжилтэд компанийн ТУЗ хяналт тавина.
- 3.3. Энэхүү хөтөлбөрийн гүйцэтгэлийн үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, хэрэгжихүйц байлгах, сайжруулах зорилгоор компанийн ТУЗ нэмэлт, өөрчлөлт оруулах эрхийг эдэлнэ.

--ooOoo--